



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi@audit.gov.mn](http://www.dornogovi@audit.gov.mn)

Дорноговь аймаг  
Сайншанд сум  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734  
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас:70523020  
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа  
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орхи нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,  
3 дугаар баг, Сайшандаг сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цахым хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2022 о.д. 24 № 1-Б/413

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДЭЛГЭРМАА ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах,

0100041

санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 117.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,272.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,030.2 сая төгрөгийн 39 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52.3 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 106.3 сая төгрөгийн 15 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 16 харилцагчдаас 17.9 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 10 зорилт, 45 арга хэмжээний хэрэгжилт 83.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 89.4 хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,302,800.92</b>	<b>210,295,673.40</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	117,587,750.88
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	117,587,750.88
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	7,638,625.00
31211	Төрийн сангийн харилцах	-	7,638,625.00
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	-	109,949,125.88
31221	Төрийн сангийн харилцах	-	109,949,125.88
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,401,086.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,401,086.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	98,901,714.92	92,707,922.52
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	21,244,735.48	21,877,995.48
35110	Тусгай зориулалттай материал	21,244,735.48	21,877,995.48
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	77,656,979.44	70,829,927.04
35410	Бичиг хэргийн материал	1,779,900.00	1,471,400.00
35420	Аж ахуйн материал	58,733,310.80	49,743,580.40
35460	Хүнсний материал	-	359,334.00
35470	Бусад хангамжийн материал	17,143,768.64	19,255,612.64
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,228,105,309.33</b>	<b>1,237,442,930.68</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,228,105,309.33	1,237,442,930.68
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,188,961,892.53	1,198,731,263.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,134,996,198.09	1,134,996,198.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113,929,581.63)	(152,229,677.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	201,927,734.03	161,727,254.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,532,512.74)	(65,556,598.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,817,193.14	107,074,570.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,563,235.48)	(43,627,999.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	69,213,350.00	58,559,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(46,927,736.94)	(28,172,167.06)
39217	Ном	25,960,484.06	25,960,484.06
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	39,143,416.80	38,711,666.88
39301	Програм хангамж	2,377,000.00	2,377,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,369,583.20)	(1,801,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,136,000.00	38,136,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,330,408,110.25</b>	<b>1,447,738,604.08</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,401,086.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,401,086.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,401,086.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,401,086.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,401,086.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,327,007,024.25</b>	<b>1,447,738,604.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,327,007,024.25	1,447,738,604.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	571,608,461.20	571,608,461.20
51101	Өмч: - төрийн	571,608,461.20	571,608,461.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	621,530,295.44	748,548,575.27
51210	Өмнөх үеийн үр дүн	621,530,295.44	637,248,020.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	111,300,554.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	133,868,267.61	127,581,567.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,330,408,110.25</b>	<b>1,447,738,604.08</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>790,971,973.00</b>	<b>1,177,975,704.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>419,500.00</b>	<b>80,354,389.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>419,500.00</b>	<b>80,354,389.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	419,500.00	8,329,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,500.00	8,329,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	169,000.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	18,820,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	2,111,844.00
120009	Бусад орлого	-	51,093,145.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>790,552,473.00</b>	<b>1,097,621,315.00</b>

1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	608,798,600.00	885,407,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	608,798,600.00	885,407,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,916,402.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,182,802.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,733,600.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	166,837,471.00	212,214,215.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	166,837,471.00	212,214,215.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>863,697,435.40</b>	<b>1,065,816,365.18</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>863,697,435.40</b>	<b>1,065,816,365.18</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	830,622,085.36	996,689,315.18
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	494,445,484.75	601,981,199.12
210101	Үндсэн цалин	355,788,634.75	460,921,038.12
210102	Нэмэгдэл	107,662,475.00	125,544,931.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,325,000.00
210104	Урамшуулал	30,994,375.00	12,190,230.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,388,406.00	75,718,900.00
210201	Тэтгэврийн даатгал	44,806,614.00	51,531,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,983,565.00	6,062,550.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,912,932.00	4,833,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	971,388.00	1,208,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,713,907.00	12,083,103.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,856,471.00	171,660,465.00
210301	Гэрэл, цахилгаан	8,342,064.00	8,646,551.00
210302	Түлш, халаалт	152,264,266.00	152,264,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,250,141.00	10,749,714.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,594,400.00	11,870,800.40
210401	Бичиг хэрэг	486,360.00	933,200.00
210402	Тээвэр, шатахуун	896,920.00	2,075,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,355,120.00	-
210404	Ном, хэвлэл	1,569,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,513,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,772,700.00	6,037,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	351,050.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,473,930.40
2105	<b>Нормативт зардал</b>	13,126,753.50	27,724,561.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,900.00	-
210502	Хоол, хүнс	12,278,853.50	27,587,061.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	570,000.00	137,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,228,100.00	7,631,300.00
210604	Урсгал засвар	3,228,100.00	7,631,300.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	188,000.00	-
210702	Дотоод албан томилолт	188,000.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,454,100.00	3,540,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,878,100.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,964,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	77,340,370.11	96,562,089.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,109,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,376,250.00	15,251,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,964,120.11	73,201,739.66
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	33,075,350.04	69,127,050.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,660,600.00	69,127,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,766,100.00	67,334,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	894,500.00	1,792,400.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,414,750.04	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,414,750.04	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(72,725,462.40)</b>	<b>112,159,338.82</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	4,474,999.70	858,783.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,474,999.70	858,783.99
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(4,474,999.70)	(858,783.99)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(77,200,462.10)</b>	<b>111,300,554.83</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>790,840,503.00</b>	<b>1,117,205,440.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>250,500.00</b>	<b>19,584,125.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	250,500.00	19,584,125.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	250,500.00	19,584,125.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,500.00	10,153,100.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		9,431,025.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>790,590,003.00</b>	<b>1,097,621,315.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	608,798,600.00	885,407,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	885,407,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	608,798,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,953,932.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,182,802.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,771,130.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	166,837,471.00	212,214,215.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	166,837,471.00	212,214,215.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>768,725,971.00</b>	<b>986,132,689.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>768,725,971.00</b>	<b>986,132,689.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>735,650,620.96</b>	<b>918,574,289.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	468,860,100.46	601,981,199.12
210101	Үндсэн цалин	330,203,250.46	460,921,038.12
210102	Нэмэгдэл	107,662,475.00	125,544,931.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,325,000.00
210104	Урамшуулал	30,994,375.00	12,190,230.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,388,406.00	75,718,900.00
210201	Тэтгэврийн даатгал	44,806,614.00	51,531,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,983,565.00	6,062,550.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,912,932.00	4,833,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	971,388.00	1,208,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,713,907.00	12,083,103.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,856,471.00	171,660,465.00
210301	Гэрэл, цахилгаан	8,342,064.00	8,646,551.00
210302	Түлш, халаалт	152,264,266.00	152,264,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,250,141.00	10,749,714.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,898,440.00	-
210401	Бичиг хэрэг	568,060.00	-
210402	Тээвэр, шатахуун	896,920.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,355,120.00	-
210404	Ном, хэвлэл	1,569,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,852,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,656,540.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	12,985,253.50	29,515,045.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,900.00	-
210502	Хоол, хүнс	12,278,853.50	29,515,045.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	428,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,721,200.00	4,235,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	653,500.00	-
210604	Урсгал засвар	4,067,700.00	4,235,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	188,000.00	-
210702	Дотоод албан томилолт	188,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,454,100.00	4,837,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,878,100.00	1,823,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,014,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,298,650.00	30,625,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,933,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,298,650.00	11,692,160.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,075,350.04</b>	<b>67,558,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,660,600.00	67,558,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,766,100.00	65,766,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	894,500.00	1,792,400.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,414,750.04	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,414,750.04	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,114,532.00</u>	<u>131,072,750.88</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,611,900.00	13,485,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,611,900.00	13,485,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,611,900.00	13,485,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,611,900.00	13,485,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(21,611,900.00)</u>	<u>(13,485,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	502,632.00	117,587,750.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	117,587,750.88

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	571,608,461.20	428,200,635.46	413,837,874.62	1,413,646,971.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	282,524,320.69	282,524,320.69
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>571,608,461.20</b>	<b>428,200,635.46</b>	<b>696,362,195.31</b>	1,696,171,291.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(294,332,367.85)	-	(294,332,367.85)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(74,831,899.87)	(74,831,899.87)
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>571,608,461.20</b>	<b>133,868,267.61</b>	<b>621,530,295.44</b>	1,327,007,024.25
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>571,608,461.20</b>	<b>133,868,267.61</b>	<b>621,530,295.44</b>	1,327,007,024.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,717,725.00	15,717,725.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>571,608,461.20</b>	<b>133,868,267.61</b>	<b>637,248,020.44</b>	1,342,724,749.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(6,286,700.00)	-	(6,286,700.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	111,300,554.83	111,300,554.83
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>571,608,461.20</b>	<b>127,581,567.61</b>	<b>748,548,575.27</b>	1,447,738,604.08

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,116,989,400.00	999,617,689.12
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,116,989,400.00	999,617,689.12
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,044,591,400.00	932,059,289.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	676,704,300.00	601,981,199.12
210101	Үндсэн цалин	510,917,900.00	460,921,038.12
210102	Нэмэгдэл	151,029,000.00	125,544,931.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,325,000.00	3,325,000.00
210104	Урамшуулал	11,432,400.00	12,190,230.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,747,600.00	75,718,900.00
210201	Тэтгэврийн даатгал	57,628,500.00	51,531,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,779,800.00	6,062,550.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,423,700.00	4,833,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,355,900.00	1,208,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,559,700.00	12,083,103.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	174,372,000.00	171,660,465.00
210301	Гэрэл, цахилгаан	11,157,800.00	8,646,551.00
210302	Түлш, халаалт	152,264,200.00	152,264,200.00
210303	Цэвэр, бохир ус	10,950,000.00	10,749,714.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,215,500.00	29,515,045.00
210502	Хоол, хүнс	31,215,500.00	29,515,045.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,000,000.00	4,235,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,235,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,002,900.00	4,837,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,150,000.00	1,823,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,852,900.00	3,014,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,549,100.00	44,110,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,769,800.00	32,418,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,779,300.00	11,692,160.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	72,398,000.00	67,558,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	72,398,000.00	67,558,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72,398,000.00	65,766,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,792,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,116,989,400.00	1,117,205,440.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	885,407,100.00	885,407,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	885,407,100.00	885,407,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	215,690,500.00	212,214,215.00
132001	Орон нутгийн төсвөөс	215,690,500.00	212,214,215.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	15,891,800.00	19,584,125.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,891,800.00	10,153,100.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		9,431,025.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>117,587,750.88</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	44.00	44.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65.7 сая төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 65.7 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа.

Үүнд:

#### Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жил тавигдаагүйгээс 1.1 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцон бүртгэснийг;
2. Түрээсийн сурах бичгийн 1.9 сая төгрөгийн орлогыг буруу бүртгэснийг;
3. Ахмадын сангийн эхний үлдэгдлийг бүртгэхдээ оны эхний үлдэгдэлд 9.4 сая төгрөгөөр өөрчлөлт хийж алдаатай бүртгэснийг;
4. Дахин үнэлсэн 51.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байсныг;
5. Үнэ төлбөргүй ирсэн 2.1 сая төгрөгийн бараа материалыг бүртгээгүй байсныг;
6. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эхний болон эцсийн үлдэгдэл санхүү байдлын тайлангийн үлдэгдлүүдээс зөрүүтэйг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 8 дугаар сард 0.4 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### 3.2 Албан шаардлага

##### 1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Анхан шатны баримтын тулгалтаар 16 харилцагчдаас 17.9 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,272.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,030.2 сая төгрөгийн 39 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52.3 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 106.3 сая төгрөгийн 15 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

#### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг ня-бо сар бүр хянаж шалгаагүй, бараа материалын тайланд барааг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу тоо ширхэгээр гаргаагүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн ашиглах жил тавигдаагүйгээс 1.1 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцон бүртгэсэн	1	1,123.6		-	1	1,123.6	1	1,123.6				
Түрээсийн сурах бичгийн 1.9 сая төгрөгийн орлогыг буруу бүртгэсэн	1	1,973.2		-	1	1,973.2	1	1,973.2				
Ахмадын сангийн эхний үлдэгдлийг бүртгэхдээ оны эхний үлдэгдэлд 9.4 сая төгрөгөөр өөрчлөлт хийж алдаатай бүртгэсэн	1	9,431.0			1	9,431.0	1	9,431.0				
Дахин үнэлсэн 51.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байсан	1	51,093.1			1	51,093.1	1	51,093.1				
Үнэ төлбөргүй ирсэн 2.1 сая төгрөгийн бараа материалыг бүртгээгүй байсан	1	2,111.8			1	2,111.8	1	2,111.8				
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эхний болон эцсийн үлдэгдэл санхүү байдлын тайлангийн үлдэгдлүүдээс зөрүүтэй байсан	1	-			1		1					
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>65,732.7</b>			<b>6</b>	<b>65,732.7</b>	<b>6</b>	<b>65,732.7</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эд хариуцагчийн гаргасан тайланг ня-бо сар бүр хянаж шалгаагүй, бараа материалын тайланд барааг Сангийн Сайддын баталсан маягтын дагуу тоо ширхэгээр гаргаагүй байна. Сар бүрийн гарын үсэг зурагдаагүй, хянагдаагүй байна.	1	-					1	-				
Тулгалтаар 16 харилцагчдаас 17.9 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1	-			1	-						
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 8 дугаар сард 0.4 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	373.9	1	373.9								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>373.9</b>	<b>1</b>	<b>373.9</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,272.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,030.2 сая төгрөгийн 39 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52.3 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 106.3 сая төгрөгийн 15 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		